

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭЭС

ЗАСГИЙН ГАЗРЫН ГИШҮҮДЭД

Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 08 дугаар сарын 14-ний өдрийн хуралдааны 27 дугаар тэмдэглэлд:

“14.1.Төрөөс орон сууцжуулалтын талаар баримтлах бодлого, төлөвлөлтийн талаар Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд Ж.Батсуурь Засгийн газрын гишүүдэд танилцуулав.

Үүнтэй холбогдуулан: 1.Орон нутагт ажиллаж байгаа төрийн албан хаагчдын орон сууц худалдан авах зээлийн хөтөлбөрт шаардагдах санхүүжилтийн эх үүсвэрийг улсын төсвийн тодотголын хүрээнд шийдвэрлүүлэх талаар арга хэмжээ авахыг Сангийн сайд Б.Жавхланд, энэ чиглэлээр хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, байгууллагатай хамтран ажиллах уулзалт, яриа зохион байгуулахыг Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд Ж.Батсуурь, Эрчим хүчний сайд Б.Чойжилсүрэн нарт даалгав.

2.Орон сууцжуулалтын талаар баримтлах, төлөвлөлтөд саналаа өгөхийг Засгийн газрын гишүүдэд, хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөр, арга хэмжээний талаар болон санхүүжилтийн эх үүсвэрийг бүрдүүлэх чиглэлээр нэгдсэн ойлголтод хүрэх уулзалт, хэлэлцүүлгийг ойрын хугацаанд зохион байгуулахыг Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд Ж.Батсуурьд даалгав.” гэжээ.



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР